



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/132

Улаанбаатар хот


Манай хороо-Миний гудамж аян
зохион байгуулах тухай


Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Хот байгуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.6.3 дах заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны "Нийслэлийн төсөв батлах тухай" 20/17 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/01 дүгээр захирамж, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр Захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил"-ийн хүрээнд "Манай хороо-Миний гудамж" аяны үйл ажиллагааг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, удирдамжийг 2 дугаар хавсралтаар, аяныг зохион байгуулахад шаардагдах төсвийн задаргааг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Аяныг батлагдсан удирдамжид заасан хугацаанд зохион байгуулж, нийслэлийн өдрийн өмнө дүгнэн, тайлан дүн мэдээг Улаанбаатар хотын Ерөнхий менежерт танилцуулахыг Ажлын хэсэг /Г.Ууганбаяр/-т даалгасугай.

3. Аяныг зохион байгуулахад шаардагдах 235,000,000 /Хоёр зуун гучин таван сая/ төгрөгийг "Хоггүй хороо, хоггүй гудамж" болзолт уралдаан, "Аз жаргалтай Улаанбаатар хот" тохижилт, ногоон байгууламжийн реалити шоу нэвтрүүлэг хийх, Мод тарьсан иргэдийн урамшуулал, Нийтийн эзэмшлийн газрыг өөрийн хөрөнгөөр тохижуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах болзолт уралдааны зардлаас тус тус гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн
А/122 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт




**“МАНАЙ ХОРОО-МИНИЙ ГУДАМЖ” АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч	Г.Ууганбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд	Э.Энхцэцэг	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
	Т.Хэрлэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга
	Ц.Рэгзэдмаа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит, дотоод хяналтын хэлтсийн дарга
	Б.Эрдэнэчимэг	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Ж.Лхагвасүрэн	Чингэлтэй дүүргийн Засаг даргын орлогч
	Ц.Шижир	Сүхбаатар дүүргийн Засаг даргын орлогч
	Г.Батсайхан	Хан-Уул дүүргийн Засаг даргын орлогч
	Э.Батбилэг	Баянгол дүүргийн Засаг даргын орлогч
	Т.Батцогт	Баянзүрх дүүргийн Засаг даргын орлогч
	О.Ганбаатар	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын орлогч
	Т.Отгонболд	Багануур дүүргийн Засаг даргын орлогч
	Б.Болормаа	Багахангай дүүргийн Засаг даргын орлогч
	С.Тунгалаг	Налайх дүүргийн Засаг даргын орлогч
	Н.Гантулга	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Дэд бүтцийн хяналтын хэлтсийн дарга
	С.Даланжаргал	Хот байгуулалт, хөгжлийн газрын Хот төлөвлөлтийн хэлтсийн дарга
	Ч.Очир	Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Газрын менежмент, төлөвлөлтийн хэлтсийн дарга
	Д.Итгэл	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн дарга
	С.Тойвгоо	Нийслэлийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн захирал

	М.Гансэлэм	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Э.Балданхүү	Баянзүрх залуучуудын давалгаа ТББ-ын тэргүүн
	О.Мэндсайхан	Нийслэлийн ногоон байгууламжийн иргэний зөвлөл ТББ-ын тэргүүн
	Э.Нямхүү	Бид байгаль элч ТББ-ын тэргүүн
	Э.Болор	Монголын ландшафтын архитектур судлалын холбоо ТББ-ын тэргүүн
	А.Нямдорж	Эрүүл мэнд нийгмийн бодлогын хүрээлэн ТББ-ын тэргүүн
	Б.Жаргал	Хотын хөгжлийг дэмжих Улаанбаатар шинэ тосгон хөдөлгөөн ТББ-ын тэргүүн
	А.Мягмардолжин	Эмэгтэйчүүдийн эрх хамгаалал хөгжлийн хүрээлэн ТББ-ын тэргүүн
	Ч.Энхжаргал	Бид туслая ТББ-ын тэргүүн
Нарийн бичгийн дарга	С.Аригуун	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	О.Оджаргал	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны ᠘ дугаар сарын 1᠐-ны өдрийн
A/132 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



"МАНАЙ ХОРОО-МИНИЙ ГУДАМЖ" АЯНЫ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, Нийслэлийн Засаг даргын 2019 оны A/01 дүгээр захирамжаар 2019 оныг "Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил" болгон зарласантай холбогдуулан нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бүх байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг идэвхижүүлэх, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, нийгмийн хариуцлагыг өндөрсгөх, тохижилт, ногоон байгууламж, хог хаягдал, цэвэрлэгээний менежментийг сайжруулах, ажлын шинэ санал санаачлагыг дэмжих, хотын өнгө үзэмжийг дээшлүүлэх замаар иргэдийн ая тухтай орчинд ажиллаж амьдрах нөхцлийг хангуулахад энэхүү аяны зорилго оршино.

Хоёр. ХАМРАХ ХҮРЭЭ, ХУГАЦАА:

2.1 Аяныг Нийслэлийн 9 дүүрэгт 2019 оны 05-р сарын 15-наас 10-р сарын 1-ний өдрийг хүртэл зохион байгуулна.

2.2 Аянд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэд хамрагдана.

Гурав. АЯНЫ ЧИГЛЭЛ:

1. Гудамж, зам, талбайг тохижуулах
2. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх
3. Байгууллага, аж ахуйн нэгжийн гадна хаяг, хаягийн байгууламжийг холбогдох журамд нийцүүлэх
4. Хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах
5. Гудамж зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх
6. Инженерийн шугам сүлжээ дэд бүтцийг сайжруулах аюулгүй байдлыг хангах

Дөрөв. АЯНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

Аяныг Нийслэлийн хэмжээнд Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн тушаалаар байгуулсан Ажлын хэсэг удирдан зохион байгуулах бөгөөд дүүрэг хороодод дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулсан дэд ажлын хэсгүүд ажиллана.

4.1 Нийслэл дэх Ажлын хэсэг:

4.1.1 Аяны хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө, үндсэн ажлын хэсгийн ажиллах хуваарийг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн тушаалаар батална.

4.1.2 Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн тушаалаар байгуулсан үндсэн Ажлын хэсэг Дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан дэд ажлын хэсгийн аяны хүрээнд хийж хэрэгжүүлж буй ажилд хяналт тавин ажиллана.

4.1.3 Аяны хүрээнд хийгдэж буй тохижилт бүтээн байгуулалтын ажлын хяналтыг 2 сар тутамд 1 удаа газар дээр нь нөхцөл байдалтай танилцаж Хотын Ерөнхий менежерийн шуурхай хуралдаанд танилцуулна.

4.1.4 Шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөт бус хяналтыг хэрэгжүүлж тайлагнаж ажиллана.

4.1.4 Аяны эцсийн тайлан мэдээг 2019 оны 10 дугаар сарын 10-ны дотор Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн зөвлөлийн хуралд танилцуулна.

Хамрагдах байгууллагууд:

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
- Хот байгуулалт, хөгжлийн газар
- Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба
- Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар
- Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар
- Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар
- Хороодын Засаг дарга нар
- Хөндлөнгийн хяналтын төрийн бус байгууллагууд

4.2 Дүүргүүд дэх Дэд ажлын хэсэг:

4.2.1 Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн тушаалаар байгуулсан Ажлын хэсэгт ажиллаж байгаа дүүргүүдийн Засаг даргын орлогч нар өөрийн дүүрэгт Дэд ажлын хэсгийг байгуулан удирдамжийн дагуу ажиллуулна.

4.2.2 Аяны хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, дэд ажлын хэсгийн ажиллах хуваарийг дүүргийн Засаг даргын захирамжаар батална.

4.2.3 Дэд ажлын хэсэг календарчилсан төлөвлөгөөний дагуу ажлаа зохион байгуулан хяналт тавьж ажиллана.

4.2.4 Дүүргийн нутаг дэвсгэрийн хороо, өрх, байгууллага аж ахуйн нэгжийн судалгаан дээр үндэслэж гаргасан төлөвлөгөөний дагуу 30 хоногт 1 удаа төлөвлөгөөт ажлын хэрэгжилт, үр дүнг тооцож, тайлан мэдээг Хотын Ерөнхий менежерийн тушаалаар байгуулсан ажлын хэсэгт сар бүрийн 10-ны дотор хүргүүлэн ажиллана.

4.2.5 Орчны тохижилтод анхаарч ажиллаагүй, дэд ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй, өнгө үзэмжийг сайжруулах чиглэлээр шаардлагатай арга хэмжээг аваагүй байгууллагад 4.2.6-д заасан “МУУ” тэмдэг, тохижилт, засвар үйлчилгээний ажлыг идэвхи, санал санаачлагатай хийж хэрэгжүүлэн ажилласан байгууллагад ажлын үр дүнгээс хамаарч “САЙН” тэмдгийг тус тус хаалганд буюу олон нийтэд ил харагдах газар нааж, дүүргийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлнэ.



Зураг № 01 “МУУ” Dislike



Зураг № 02 “САЙН” Like

4.2.7 Үндсэн болон дэд ажлын хэсгүүдээс орчны тохижилт, иргэдийн эрүүл аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр нийслэлийн нутгийн захиргаа, төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлсэн санал хүсэлтийг холбогдох байгууллагууд хүлээн авч шуурхай шийдвэрлэх, эргэн мэдээлэх чиглэлээр бүх түвшинд дэмжлэг туслалцаа үзүүлж хамтран ажиллана. /“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК, “Геодези, усны барилга байгууламжийн газар” ОНӨААТҮГ, “Ус сувгийн удирдах газар” ОНӨҮГ, “Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ, “Улаанбаатар хотын Шуурхай удирдлага зохицуулалтын төв” ОНӨҮГ/ бусад холбогдох байгууллага

4.3 Иргэн, хуулийн этгээдийн оролцоо

Иргэн, хуулийн этгээд нь тохижилт, ногоон байгууламж, орчны бохирдлыг бууруулах, бүтээн байгуулалтын ажилд идэвхи санаачлагатай оролцож, Хог хаягдлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

Тав. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЧИГ ҮҮРЭГ

Д/д	Байгууллагын нэр	Хариуцах хэлтэс, алба	Хариуцах ажлын чиглэл
1	Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	<ul style="list-style-type: none"> Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс Захиргаа, санхүүгийн хэлтэс 	<ul style="list-style-type: none"> Аяны хүрээнд зохион байгуулж буй ажил, хүрч буй үр дүнгийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр мэдээлж олон нийтэд таниулах, сурталчилах Ярилцлагын цаг нэвтрүүлгийг бэлтгэн цацах (МУОНРТ, UBS ТВ, TV5 ТВ)
2	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	<ul style="list-style-type: none"> Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс 	<ul style="list-style-type: none"> Мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах Дүүргүүдээс ирүүлсэн тайлан мэдээг нэгтгэж Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн Зөвлөлийн хуралд танилцуулах Аяны хүрээнд дүүргүүдийн дэд ажлын хэсгүүдийн төлөвлөгөөний гүйцэтгэлд явцын

			хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгч, үр дүнг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авч ажиллах
		• Аудит дотоод хяналтын хэлтэс	• Аяны хүрээнд дүүргүүдэд хийгдэж буй тохижилт, бүтээн байгуулалт, засвар үйлчилгээний ажилд хяналт, шинжилгээ хийж эрчимжүүлэх үүрэг даалгавар өгч ажиллах
3	Нийслэлийн Мэдээллийн технологийн газар	• Захиргаа, санхүүгийн хэлтэс • Мэдээллийн сүлжээ, техник, хяналтын хэлтэс	• Manaikhoroo.mn хуудсын баяжилтыг хэрхэн хийх талаар сургалт зохион байгуулах • Manaikhoroo.mn хуудасны баяжилтад хяналт тавьж ажиллах
4	Хот байгуулалт хөгжлийн газар	• Хот төлөвлөлтийн хэлтэс	• Дүүргүүдэд хийгдэж буй тохижилт, бүтээн байгуулалтын ажил хот төлөвлөлтийн дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах • Илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах
5	Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба	• Газрын менежмент, төлөвлөлтийн хэлтэс	• Аяны хүрээнд хийгдэж буй тохижилт, бүтээн байгуулалтын ажил нь газрын маргаангүй, өөрийн эзэмшлийн эсхүл нийтийн эзэмшлийн талбайд хийгдэж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах • Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж ажиллах
6	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар	• Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтэс	• Аяны хүрээнд хийгдэж буй тохижилт, бүтээн байгуулалтын ажлыг өмч бүртгэлд бүртгэлжүүлэх, эзэнжүүлж буй эсэхэд хяналт тавьж ажиллах • Илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах
7	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар	• Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын хэлтэс • Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэр, үйлчилгээний хяналтын хэлтэс • Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын хэлтэс	• Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/03 албан даалгаварын хэрэгжилтийг хангуулан ажиллах • Дүүргүүдэд хийгдэж буй тохижилт, бүтээн байгуулалт, засвар үйлчилгээний ажилд зөрчил дутагдал гарч буй эсэхэд хяналт тавьж ажиллах • Тохижилт, бүтээн байгуулалт, засвар үйлчилгээний чиглэлээр зөрчил дутагдлыг арилгуулж захиргааны хариуцлага хүлээлгэх /торгууль, шийтгэврийн хуудас оногдуулах/ • Удаа дараа зөрчил дутагдал гаргасан байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр болон бүр мөсөн зогсоох хүртэл арга хэмжээ авах • Тайлан мэдээг сар бүрийн 05-ны өдөр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба Ажлын хэсэгт ирүүлэх
8	Дүүргүүдийн Засаг даргын тамгын газар	• Дэд ажлын хэсэг	• Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/03 албан даалгаварын хэрэгжилтийг хангуулан ажиллах • Дүүргийн нутаг дэвсгэрт хийгдэж буй тохижилт, бүтээн байгуулалт, засвар үйлчилгээний ажлын тайлан мэдээг хороо тус бүрээр гаргаж сар бүрийн 10-ны өдөр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба Ажлын хэсэгт ирүүлэх • Manaikhoroo.mn вэб сайтын баяжилтыг цаг тухай бүр нь хийсэн байх

9	Хороодын Засаг дарга нар	<ul style="list-style-type: none"> Дэд ажлын хэсэг 	<ul style="list-style-type: none"> Хорооны нутаг дэвсгэрт хийгдэж буй тохижилт, бүтээн байгуулалт, засвар үйлчилгээний ажилд байнгын хяналт тавьж ажиллах Тайлан мэдээг сар бүрийн 05-ны өдөр дүүргийн Засаг даргын тамгын газрын асуудал хариуцсан хэлтсээр хянуулж, дүүргийн Засаг даргын тамгын газраас Захирагчийн ажлын албаны Ажлын хэсэгт ирүүлэх Manaikhoogo.mn вэб сайтын баяжилтыг цаг тухайд нь хийж байх
10	Хог хаягдлын чиглэлээр хяналт тавин ажиллаж буй ТББ-ууд	<ul style="list-style-type: none"> Ажлын хэсэг 	<ul style="list-style-type: none"> Хог хаягдлын цэвэрлэгээ үйлчилгээнд өдөр тутмын хяналт тавьж ажиллах Зөрчил дутагдлыг арилгуулах талаар хариуцсан байгууллагад мэдэгдэх

Зургаа. АЯНЫГ ДҮГНЭХ:

6.2 Аяны дүнг дүүрэг бүрээр дүгнэж гаргана.

Аяны хүрээнд хийгдсэн ажлыг дүгнэхдээ дараах үзүүлэлтээр дүгнэнэ.

6.1.1 Шилдэг дүүрэг

6.1.2 Шилдэг хороо /Орон сууцны болон гэр хороо/

6.1.3 Шилдэг байгууллага, аж ахуйн нэгж /орон сууцны болон гэр хороо/

6.1.4 Шилдэг өрх

6.1.5 Шилдэг хог хаягдлын үйлчилгээний байгууллага

6.3 Нэр дэвшигчдийг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэж шалгаруулна.

Д/д	6.2.1 Шилдэг дүүрэг шалгаруулах шалгуур үзүүлэлт
1	Аяны хүрээнд иргэд олон нийтийг хамарсан идэвхижүүлэлтийн ажлыг зохион байгуулсан байдал
2	Иргэд олон нийтэд зориулагдсан иж бүрэн тохижилт бүхий талбайг нэмэгдүүлсэн байдал <ul style="list-style-type: none"> Шинээр Арчлалт засвар шинэчлэлт хийсэн
3	Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж зорчих хэсгийн шийдлийг хийсэн байдал
4	Мод, бут, сөөг тарьж зүлэгжүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэцгийн мандал байгуулах ажлыг зохион байгуулсан байдал
5	Шарилжгүй Улаанбаатар аяны хүрээнд шарилж, хөл газрын ургамлын ургалт, тархалтыг бууруулах, хадах, цэвэрлэх ажлыг зохион байгуулсан байдал
6	Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлсэн байдал <ul style="list-style-type: none"> Шинээр Шинэчлэн засварласан
7	МУ-ын Засгийн газрын 2013 оны 37-р тогтоол, НИТХ-ын 2017 оны 9/10 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулахад дагаж мөрдөх журам", Аж ахуйн нэгж, байгууллагын хаяг, реклам, гадна зар сурталчилгааг стандартын дагуу шинэчлэх, шөнийн гэрэлтүүлэгтэй болгох ГАДНА ХАЯГ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛАМЖИД ТАВИГДАХ ШААРДЛАГА /Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2014 оны А/149 дүгээр тушаалыг мөрдлөг болгон ажилласан байдал
8	Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд сандал, хогийн сав байршуулсан байдал <ul style="list-style-type: none"> Шинээр Засварлаж өнгө үзэмжийг сайжруулсан

9	Явган хүний зам, машины зогсоолыг засварлаж тохижуулах, таних тэмдэг, тэмдэг тэмдэглэгээтэй болгосон байдал /Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2018 оны А/289 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ажиллах/
10	Архитектурын жижиг байгууламжийг тохижилтын ажилд ашигласан байдал /Хөшөө дурсгал, гудамж талбайд мониментал, усан оргилуур г.м/
11	Хог хаягдлын хуулийн хэрэгжилтийг хангуулсан, хэрэгжилт үр дүнг тооцож ажилласан, аж ахуйн нэгж, байгууллагын идэвхи хандлагыг өрнүүлсэн байдал
12	Бүх нийтийн их цэвэрлэгээний ажилд идэвхи санаачлагатай оролцсон байдал /Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/285 дугаар захирамжийн хэрэгжилт/
13	Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг цаг тухайд нь арилгуулж ажилласан байдал
14	Дүүргийн нутаг дэвсгэрт хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах, бүтээгдэхүүн болгох үйл ажиллагааг хэвшүүлсэн, хог хаягдлыг ангилан ялгах байгууллагуудтай хамтарч ажилласан байдал
15	Хувийн болон төсвийн хөрөнгөөр хийгдсэн тохижилтын ажлын үр дүнд бий болсон хөрөнгийг эзэнжүүлэн, холбогдох байгууллагын хөрөнгөнд бүртгүүлсэн, эзэнжүүлж, арчлалтын ажлыг зохион байгуулсан байдал
16	Иргэдийн аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөл бололцоог хангах зорилгоор камержуулалт хийсэн байдал
17	Гэр хорооллын гудамж, айл өрхийн хаягжуулалтыг загвар дизайнтай үзэмжтэй байдлаар хаягжуулсан байдал
18	Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн засвар үйлчилгээ, хог хаягдал, тунгаагуурыг тогтмол цэвэрлэсэн байдал
19	Борооны болон хөрсний ус зайлуулах инженерийн шугам сүлжээний үзлэгийн худгийн бүрэн аюулгүй байдлыг хангуулж, илэрсэн зөрчил дутагдлыг ашиглагч байгууллагад мэдээлж зохих арга хэмжээг авсан байдал
20	Утаагүй түлш, сайжруулсан зуух ашиглуулж агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр ажил зохион байгуулсан байдал
21	Түргэн үйлчилгээний цэг болон зөвшөөрөлгүй ил задгай худалдааг цэгцэлсэн байдал
22	Manaikhогоо.mn хуудас баяжилтыг хийж мэдээллийн сангийн шинэчлэлийг цаг тухай бүрд нь хийсэн байдал
23	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2018 оны А/326 дугаар тушаалын хэрэгжилтийн байдал

Д/д	6.2.2 Шилдэг орон сууцны хороо шалгаруулах шалгуур үзүүлэлт
1	Аяны хүрээнд иргэд олон нийтийг хамарсан идэвхижүүлэлтийн ажлыг зохион байгуулсан байдал
2	Иргэд олон нийтэд зориулсан иж бүрэн тохижилт бүхий талбайг нэмсэн байдал - Шинээр - Арчлалт засвар шинэчлэлт хийсэн
3	Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж зорчих хэсгийн шийдлийг хийсэн байдал
4	Мод, бут, сөөг тарьж зүлэгжүүлэх, ногоон байгууламжийг нэмэх, цэцгийн мандал байгуулах ажлыг зохион байгуулсан байдал
5	Шарилжгүй Улаанбаатар аяны хүрээнд аж ахуйн нэгж байгууллага, хороог оролцуулж хөл газрын ургамлын ургалт тархалтыг бууруулах ажлыг зохион байгуулсан байдал
6	Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлсэн байдал
7	МУ-ын Засгийн газрын 2013 оны 37-р тогтоол, НИТХ-ын 2017 оны 9/10 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулахад дагаж мөрдөх журам", Аж ахуйн нэгж, байгууллагын хаяг, реклам, гадна зар сурталчилгааг стандартын дагуу шинэчлэх, шөнийн гэрэлтүүлэгтэй болгох ГАДНА ХАЯГ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛАМЖИД ТАВИГДАХ ШААРДЛАГА /Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2014 оны А/149 дүгээр тушаалыг мөрдлөг болгон ажилласан байдал
8	Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд сандал, хогийн сав байршуулсан байдал - Шинээр - Засварлаж өнгө үзэмжийг сайжруулсан
9	Явган хүний зам, машины зогсоолыг засварлаж тохижуулах, таних тэмдэг, тэмдэг тэмдэглэгээтэй болгосон байдал
10	Архитектурын жижиг байгууламжийг тохижилтын ажилд ашигласан байдал /Хөшөө дурсгал, гудамж талбайд мониментал, усан оргилуур г.м/

11	Хог хаягдлын хуулийн хэрэгжилтийг хангуулсан, хэрэгжилт үр дүнг тооцож ажилласан, аж ахуйн нэгж, байгууллагын идэвхи хандлагыг өрнүүлсэн байдал
12	Бүх нийтийн их цэвэрлэгээний ажилд идэвхи санаачлагатай оролцсон байдал
13	Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг цаг тухайд нь арилгуулж ажилласан байдал
14	Хорооны нутаг дэвсгэрт хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах, бүтээгдэхүүн болгох үйл ажиллагааг хэвшүүлсэн, хог хаягдлыг ангилан ялгах байгууллагуудтай хамтарч ажилласан байдал
15	Гудамж зам талбайг стандартын хаягаар хаягжуулсан байдал
16	Гэрэлтүүлгийн ашиглагч байгууллагуудтай ажил хэргийн байнгын холбоотой ажиллаж асалтын горимыг баримтлах, энэ талаар иргэдийн санал гомдлыг гаргаагүй ажилласан байдал
17	Нутаг дэвсгэрийн хэмжээнд үүсмэл болон хур хогийн цэгүүдийн тоог бууруулсан, газрыг ариутгаж халдваргүйжүүлсэн байдал
18	Хорооны айл өрхүүдийг хөршийн холбоонд хамруулж, иргэд хоорондын соёлтой харилцааг бий болгох тал дээр ажил зохион байгуулсан байдал
19	Төсвийн хөрөнгөөр хийгдсэн тохижилтын ажлын үр дүнд бий болсон хөрөнгийг эзэнжүүлэн, холбогдох байгууллагын хөрөнгөнд бүртгүүлсэн байдал
20	Иргэдийн аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөл бололцоог хангах зорилгоор камержуулалт хийсэн байдал
21	Түргэн үйлчилгээний цэг болон зөвшөөрөлгүй ил задгай худалдааг цэгцэлсэн байдал
22	Автобусны буудлуудыг тохижуулсан, саравч сүүдрэвчний өнгө үзэмжийг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
23	Эзэнтэй нохойг бүртгэлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан байдал
24	Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн засвар үйлчилгээ, хог хаягдал, тунгаагуурыг тогтмол цэвэрлэсэн байдал
25	Борооны болон хөрсний ус зайлуулах инженерийн шугам сүлжээний үзлэгийн худгийн бүрэн аюулгүй байдлыг хангуулж, илэрсэн зөрчил дутагдлыг ашиглагч байгууллагад мэдээлж зохих арга хэмжээг авсан байдал
26	Manaikhoogo.mn хуудас баяжилтыг хийж мэдээллийн сангийн шинэчлэлийг цаг тухай бүрд нь хийсэн байдал

Д/д	6.2.3 Шилдэг гэр хороо шалгаруулах шалгуур үзүүлэлт
1	Аяны хүрээнд иргэд олон нийтийг хамарсан идэвхижүүлэлтийн ажлыг зохион байгуулсан байдал
2	Иргэд олон нийтэд зориулагдсан иж бүрэн тохижилт бүхий талбайг нэмэгдүүлсэн байдал - Шинээр - Арчлалт засвар шинэчлэлт хийсэн
3	Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж зорчих хэсгийн шийдлийг хийсэн байдал
4	Мод, бут, сөөг тарьж зүлэгжүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэцгийн мандал байгуулах ажлыг зохион байгуулсан байдал
5	Шарилжгүй Улаанбаатар аяны хүрээнд аж ахуйн нэгж байгууллага, хороог оролцуулж хөл газрын ургамлын ургалт тархалтыг бууруулах ажлыг зохион байгуулсан байдал
6	Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлсэн байдал
7	МУ-ын Засгийн газрын 2013 оны 37-р тогтоол, НИТХ-ын 2017 оны 9/10 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулахад дагаж мөрдөх журам", Аж ахуйн нэгж, байгууллагын хаяг, реклам, гадна зар сурталчилгааг стандартын дагуу шинэчлэх, шөнийн гэрэлтүүлэгтэй болгох ГАДНА ХАЯГ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛАМЖИД ТАВИГДАХ ШААРДЛАГА /Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2014 оны А/149 дүгээр тушаалыг мөрдлөг болгон ажилласан байдал
8	Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд сандал, хогийн сав байршуулсан байдал - Шинээр - Засварлаж өнгө үзэмжийг сайжруулсан
9	Архитектурын жижиг байгууламжийг тохижилтын ажилд ашигласан байдал /Хөшөө дурсгал, гудамж талбайд монументал, усан оргилуур г.м/
10	Хог хаягдлын хуулийн хэрэгжилтийг хангуулсан, хэрэгжилт үр дүнг тооцож ажилласан, аж ахуйн нэгж, байгууллагын идэвхи хандлагыг өрнүүлсэн байдал
11	Бүх нийтийн их цэвэрлэгээний ажилд идэвхи санаачлагатай оролцсон байдал
12	Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг цаг тухайд нь арилгуулж ажилласан байдал

13	Хорооны нутаг дэвсгэрт хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах, бүтээгдэхүүн болгох үйл ажиллагааг хэвшүүлсэн, хог хаягдлыг ангилан ялгах байгууллагуудтай хамтарч ажилласан байдал
14	Гудамж зам талбайг стандартын хаягаар хаягжуулсан байдал
15	Гэрэлтүүлгийн ашиглагч байгууллагуудтай ажил хэргийн байнгын холбоотой ажиллаж асалтын горимыг баримтлах, энэ талаар иргэдийн санал гомдлыг гаргаагүй ажилласан байдал
16	Нутаг дэвсгэрийн хэмжээнд үүсмэл болон хур хогийн цэгүүдийн тоог бууруулсан, газрыг ариутгаж халдваргүйжүүлсэн байдал
17	Хорооны айл өрхүүдийг хөршийн холбоонд хамруулж, иргэд хоорондын соёлтой харилцааг бий болгох тал дээр ажил зохион байгуулсан байдал
18	Төсвийн хөрөнгөөр хийгдсэн тохижилтын ажлын үр дүнд бий болсон хөрөнгийг эзэнжүүлэн, холбогдох байгууллагын хөрөнгөнд бүртгүүлсэн байдал
19	Иргэдийн аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөл бололцоог хангах зорилгоор камержуулалт хийсэн байдал
20	Түргэн үйлчилгээний цэг болон зөвшөөрөлгүй ил задгай худалдааг цэгцэлсэн байдал
21	Автобусны буудлуудыг тохижуулсан, саравч сүүдрэвчний өнгө үзэмжийг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
22	Эзэнтэй нохойг бүртгэлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан байдал
23	Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн засвар үйлчилгээ, хог хаягдал, тунгаагуурыг тогтмол цэвэрлэсэн байдал
24	Борооны болон хөрсний ус зайлуулах инженерийн шугам сүлжээний үзлэгийн худгийн бүрэн аюулгүй байдлыг хангуулж, илэрсэн зөрчил дутагдлыг ашиглагч байгууллагад мэдээлж зохих арга хэмжээг авсан байдал
25	Утаагүй түлш, сайжруулсан зуух ашиглуулж агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр ажил зохион байгуулсан байдал
26	Manaikhoroо.mn хуудас баяжилтыг хийж мэдээллийн сангийн шинэчлэлийг цаг тухай бүрд нь хийсэн байдал

Д/д	6.2.4 Шилдэг байгууллага, аж ахуйн нэгж шалгаруулах шалгуур үзүүлэлт /Орон сууцны хороо/
1	Өөрийн хөрөнгөөр иргэд олон нийтэд зориулагдсан иж бүрэн тохижилт бүхий талбайг нэмэгдүүлсэн байдал
2	Мод, бут, сөөг тарьж зүлэгжүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэцгийн мандал байгуулах ажлыг зохион байгуулсан байдал
3	Шарилжгүй Улаанбаатар аяны хүрээнд шарилж, хөл газрын ургамлын ургалт, тархалтыг бууруулах, хадах, цэвэрлэх ажлыг зохион байгуулсан байдал
4	Орчны гэрэлтүүлгийг нэмэгдүүлсэн байдал
5	Гадна хаяг, мэдээллийн байгууламжид орчин үеийн техник тоног төхөөрөмжийг ашигласан байдал
6	МУ-ын Засгийн газрын 2013 оны 37-р тогтоол, НИТХ-ын 2017 оны 9/10 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулахад дагаж мөрдөх журам", Аж ахуйн нэгж, байгууллагын хаяг, реклам, гадна зар сурталчилгааг стандартын дагуу шинэчлэх, шөнийн гэрэлтүүлэгтэй болгох ГАДНА ХАЯГ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛАМЖИД ТАВИГДАХ ШААРДЛАГА /Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2014 оны А/149 дүгээр тушаалыг мөрдлөг болгон ажилласан байдал
7	Сандал, хогийн савыг байршуулсан байдал
8	Барилгын гадна фасадыг /экстерьер/ орчинтой уялдуулж, орц гарцын явган зам, тэмдэг тэмдэглэгээ, дэд бүтцийн асуудлыг иж бүрнээр шийдсэн байдал
9	Явган хүний зам, машины зогсоолыг засварлаж тохижуулах, таних тэмдэг, тэмдэг тэмдэглэгээтэй болгосон байдал
10	Архитектурын жижиг байгууламжийг тохижилтын ажилд ашигласан байдал /Хөшөө дурсгал, гудамж талбайд монументал, усан оргилуур г.м/
11	Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа нь холбогдох стандарт, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан байдал
12	"Хог тээврийн гэрээ", "Тохижилт, цэвэрлэгээний гэрээ"-г дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагууд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр байгуулж хугацаанд нь дүгнүүлж, сунгуулсан байдал

13	Хог хаягдлын хуулийн хэрэгжилтийг хангуулсан, хэрэгжилт үр дүнг тооцож ажилласан, аж ахуйн нэгж, байгууллагын идэвхи хандлагыг өрнүүлсэн байдал
14	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгж, байгууллага нь барилгын гадна фасад, хашаа, хана, цонх, хаалга, шат довжоо, талбай, хаяг рекламьг тогтмол угааж цэвэрлэн өнгө үзэмжтэй байлгасан байх
15	Нийслэл, ТББ, хувийн хэвшлийн байгууллагуудаас зохион байгуулсан их цэвэрлэгээний ажилд тогтмол идэвх санаачлагатай оролцсон байдал
16	Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг цаг тухайд нь арилгаж ажилласан байдал
17	Байгууллагаас гарч буй хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын уут саванд түр хадгалах байдлаар хог тээвэрлэгч компанид хүлээлгэн өгч хэвшсэн байдал
18	Аж ахуй нэгж байгууллага бүр гадна талдаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөл бололцоог хангах зорилгоор камержуулалт хийсэн байдал

Д/д	6.2.5 Шилдэг байгууллага, аж ахуйн нэгж шалгаруулах шалгуур үзүүлэлт /Гэр хороо/
1	Өөрийн хөрөнгөөр иргэд олон нийтэд зориулагдсан иж бүрэн тохижилт бүхий талбайг нэмэгдүүлсэн байдал
2	Мод, бут, сөөг тарьж зүлэгжүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэцгийн мандал байгуулах ажлыг зохион байгуулсан байдал
3	Шарилжгүй Улаанбаатар аяны хүрээнд шарилж, хөл газрын ургамлын ургалт, тархалтыг бууруулах, хадах, цэвэрлэх ажлыг зохион байгуулсан байдал
4	Орчны гэрэлтүүлгийг нэмэгдүүлсэн байдал
5	Гадна хаягийг орчин үеийн техник тоног төхөөрөмжийг ашигласан байдал
6	МУ-ын Засгийн газрын 2013 оны 37-р тогтоол, НИТХ-ын 2017 оны 9/10 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулахад дагаж мөрдөх журам", Аж ахуйн нэгж, байгууллагын хаяг, реклам, гадна зар сурталчилгааг стандартын дагуу шинэчлэх, шөнийн гэрэлтүүлэгтэй болгох ГАДНА ХАЯГ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛАМЖИД ТАВИГДАХ ШААРДЛАГА /Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2014 оны А/149 дүгээр тушаалыг мөрдлөг болгон ажилласан байдал
7	Сандал, хогийн савыг байршуулсан байдал
8	Барилгын гадна фасадыг /экстерьер/ орчинтой уялдуулж орц гарцын явган зам, тэмдэг тэмдэглэгээ, дэд бүтцийн асуудлыг иж бүрнээр шийдсэн байдал
9	Явган хүний зам, машины зогсоолыг засварлаж тохижуулах, таних тэмдэг, тэмдэг тэмдэглэгээтэй болгосон байдал
10	Архитектурын жижиг байгууламжийг тохижилтын ажилд ашигласан байдал /Хөшөө дурсгал, гудамж талбайд мониментал, усан оргилуур г.м/
11	Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа нь холбогдох стандарт, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан байдал
12	"Хог тээврийн гэрээ", "Тохижилт, цэвэрлэгээний гэрээ"-г дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагууд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр байгуулж хугацаанд нь дүгнүүлж, сунгуулсан байдал
13	Хог хаягдлын хуулийн хэрэгжилтийг хангуулсан, хэрэгжилт үр дүнг тооцож ажилласан, аж ахуйн нэгж, байгууллагын идэвхи хандлагыг өрнүүлсэн байдал
14	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгж, байгууллагын барилгын гадна фасад, хашаа, хана, цонх, хаалга, шат довжоо, талбай, хаяг рекламьг тогтмол угааж цэвэрлэн өнгө үзэмжтэй байлгасан байх
15	Нийслэл, ТББ, хувийн хэвшлийн байгууллагуудаас зохион байгуулсан их цэвэрлэгээний ажилд тогтмол идэвх санаачлагатай оролцсон байдал
16	Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг цаг тухайд нь арилгаж ажилласан байдал
17	Байгууллагаас гарч буй хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын уут саванд түр хадгалах байдлаар хог тээвэрлэгч компанид хүлээлгэн өгч хэвшсэн байдал
18	Аж ахуй нэгж байгууллага бүр гадна талдаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөл бололцоог хангах зорилгоор камержуулалт хийсэн байдал
19	Жорлон, муу усны нүх, хөрсний бохирдлыг багасгах чиглэлээр тодорхой ажлыг хийж MNS 5924;2015 стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр ажилласан байдал
20	Утаагүй түлш, сайжруулсан зуух, цахилгаан халаалт ашиглаж агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмрээ оруулсан байх

Д/д	6.2.6 Шилдэг өрх шалгаруулах шалгуур үзүүлэлт
1	Хашааны гадна дотор талбайг тохижуулсан байдал
2	Хашааны өнгө үзэмжийг сэргээн засварласан байдал
3	Орчны гэрэлтүүлгийг шийдвэрлэсэн байдал
4	Явган зам бусад хатуу хучилттай талбайг нэмэгдүүлсэн байдал
5	Хөрш айлуудтайгаа хамтран шинэ санал санаачлага гарган нэвтрүүлэх, хөршийн холбоог сайжруулан хамтын ажиллагааг бэхжүүлсэн байдал
6	Хашаандаа мод, бут, сөөг тарьж зүлэгжүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэцгийн мандал байгуулах ажлыг зохион байгуулсан байдал
7	Хог хаягдлыг ангилан ялгах хогийн сав байршуулсан байдал
8	Жорлон, муу усны нүх, хөрсний бохирдлыг багасгах чиглэлээр тодорхой ажлыг хийж хэрэгжүүлсэн, MNS 5924;2015 стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр ажилласан байдал
9	Амралтын орчин бүхий сандал, сүүдрэвч зэргийг хийж хэрэгжүүлсэн байдал
10	Хашаа, гудамжаа шаардлага хангасан стандартын хаягаар хаягжуулсан байдал
11	Нохойгоо бүртгэлжүүлэх үйл ажиллагаанд оролцсон байдал
12	Хог тээврийн байгууллагаар хог хаягдлаа тээвэрлүүлэх ажлыг тогтмолжуулсан байдал
13	Утаагүй түлш, сайжруулсан зуух, цахилгаан халаалт ашиглаж агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмрээ оруулсан байх
14	Нийслэл, дүүрэг, хорооноос зохион байгуулсан бүх нийтийн их цэвэрлэгээ, хөл газрын ургамалтай тэмцэх, цас мөс хальтиргаа гулгаа арилгах ажилд оролцсон байдал, бусдын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан санал санаачлага гаргасан байдал

Д/д	6.2.7 Шилдэг хог хаягдлын үйлчилгээний байгууллага шалгаруулах шалгуур үзүүлэлт
1	Үйлчилгээ үзүүлж буй бүсийн хороодтой хамтран ажилласан байдал
2	Гудамж зам талбайн цэвэрлэгээний хуваарь гаргаж, дүүргийн асуудал хариуцсан Засаг даргын орлогчоор батлуулах, баталсан хуваарийн дагуу ажилласан байдлын өдөр тутмын бүртгэл хөтлөх, тайлан гаргах
3	Зам талбайн үйлчлэгчдийн дунд ажлын ур чадвартай, өндөр бүтээмжтэй үйлчлэгч шалгаруулах арга хэмжээ зохион байгуулах
4	Цалин урамшууллын шинэлэг систем нэвтрүүлсэн байх
5	Зам талбайн үйлчлэгчдийг ажлын хувцас, цэвэрлэгээний багаж хэрэгсэлээр хангасан байх
6	Зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээний зуны цагийн хуваарьт шилжүүлэх буюу өглөө 5:00 цагт ажил эхлүүлж хэвших /Шөнийн цэвэрлэгээний хуваарь гарган ажиллаж хэвших/
7	Зам талбай болон зам дагуух ногоон байгууламжийн арчилгаа усалгааг 7 хоногт 3 удаа 5:00-7:22:00-24:00 цагийн хооронд хийж гүйцэтгэж хэвших, шарилж, луулийг хадаж цэвэрлэсэн байдал
8	Гудамж зам талбайн хогийн саванд хуримтлагдсан хог хаягдлыг цуглуулах, маршрут, хуваарь гаргаж мөрдүүлэх, хогийн сав, сандлын тоос шороог арчиж цэвэрлэж хэвших
9	Ажил эхлэхийн өмнө хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч, тэмдэглэл хөтлүүлж хэвших
10	Айл өрх, байгууллага аж ахуйн нэгжийн хог цуглуулж, тээвэрлэх хуваарь, маршрутыг хороотой хамтран боловсруулж, дүүргийн Засаг даргын орлогчоор батлуулан мөрдөх
11	Ил задгай тогтмол үүсдэг үүсмэл хогийн цэгүүдийг дахин үүсгэхгүй байх арга хэмжээг авч, устгасан байх
12	Ажлын ур чадвартай, өндөр бүтээмжтэй жолооч, ачигч шалгаруулах арга хэмжээ зохион байгуулах
13	Хог тээврийн автомашины бүрэн бүтэн байдал, урсгал засвар үйлчилгээг тогтмол хийсэн байдал, өдөр бүр угааж цэвэрлэж хэвших
14	Ачигч, жолоочийг ажлын жигд хувцасаар хангаж, тогтмол өмсөж хэвшүүлэх

6.3 Дээрх шалгуур үзүүлэлтүүдээс гадна дүүрэг, хорооны зохион байгуулалтын арга хэмжээнд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллага, САЙН болон МУУ тусгай тэмдэглэгээг авсан байдал зэргийг нэмэлт үзүүлэлтээр харгалзан дүгнэнэ.

6.4 Дүүргийн дэд ажлын хэсэг нь шилдгүүдийг дараах тоо хэмжээгээр нэр дэвшүүлэх ба удирдамжийн 6.2-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу нэр дэвшигчдийг үнэлж дүгнэн, холбогдох тайлангуудын хамт ажлын хэсэгт ирүүлнэ.

Д/д	Дүүрэг	Шилдэгт өрсөлдүүлэх нэр дэвшигчдийн тоо				
		Шилдэг хороо		Шилдэг ААН		Шилдэг өрх
		ОС	ГХ	ОС	ГХ	ГХ
1	Баянгол	2	1	3	1	1
2	Баянзүрх	1	3	2	3	2
3	Сүхбаатар	1	3	2	1	1
4	Сонгинохайрхан	1	3	1	3	2
5	Хан-Уул	1	2	2	1	1
6	Чингэлтэй	1	2	2	2	1
7	Багануур	1	1	1	1	1
8	Налайх	1	1	1	1	1
9	Багахангай	1	1	1	1	1
Нийт		10	17	15	14	11

6.5 Шилдэг дүүргийг удирдамжийн 6.2.1-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж шалгаруулах тул дүүргийн ажлын хэсгүүд шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн ажлын тайланг бэлтгэж үндсэн ажлын хэсэгт ирүүлнэ.

6.6 Шилдэг хог хаягдлын үйлчилгээний байгууллагыг удирдамжийн 6.2.7-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж шалгаруулах тул хог хаягдлын үйлчилгээний байгууллагууд шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн ажлын тайланг бэлтгэж үндсэн ажлын хэсэгт ирүүлнэ.

6.7 Үнэлгээг шалгуур үзүүлэлт тус бүрээр ажлын хэсгийн гишүүн бүр үнэлж, гишүүдийн үнэлгээний нийлбэрээр хамгийн өндөр үнэлгээ авсан нэр дэвшигчийг эхэнд жагсаах байдлаар эрэмбэлж байр эзлүүлэх ба үнэлгээг дараах тоон утгаар өгнө.

- 91-100%-ийн гүйцэтгэлд 4.6 - 5.0 оноо
- 81-90%-ийн гүйцэтгэлд 4.1 - 4.5 оноо
- 71-80%-ийн гүйцэтгэлд 3.6 - 4.0 оноо
- 61-70%-ийн гүйцэтгэлд 3.1 - 3.5 оноо
- 51-60%-ийн гүйцэтгэлд 2.6 - 3.0 оноо
- 41-50%-ийн гүйцэтгэлд 2.1 - 2.5 оноо
- 30-40%-ийн гүйцэтгэлд 0.1 - 2.0 оноогоор тус тус тооцно.
- 30%-с доош бол үнэлгээ өгөхгүй

6.8 Нэр дэвшигчдийн үнэлэгдсэн тайланг үндсэн ажлын хэсэг 2019 оны 9 дүгээр сарын 20-ны дотор хүлээн авч 10 дугаар сарын 10-ны дотор үнэлгээг хийж, эцсийн дүнг гаргаж, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан, дүнг олон нийтэд зарлана.

Долоо. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

7.1 Аяны хүрээнд идэвхи санаачлагатай оролцсон Шилдэг дүүрэг, хороо, өрх, байгууллага, аж ахуйн нэгж, хог хаягдлын үйлчилгээний байгууллагыг дараах тоо хэмжээгээр байр эзлүүлж өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулна.

7.1.1 Шилдэг дүүрэг:

- I дүгээр байр - 1. Өргөмжлөл, 8.000.000 төгрөг + аялах эрх 3
- II дугаар байр - 1. Өргөмжлөл, 6.000.000 төгрөг + аялах эрх 2
- III дугаар байр - 1. Өргөмжлөл, 4.000.000 төгрөг + аялах эрх 1

7.1.2 Шилдэг байгууллага, аж ахуйн нэгж /орон сууцны хороо/:

- I дүгээр байр - 1. Өргөмжлөл, 5.000.000 төгрөг
- II дугаар байр - 1. Өргөмжлөл, 3.000.000 төгрөг
- III дугаар байр - 1. Өргөмжлөл, 2.000.000 төгрөг
- Тусгай байр - 5. Өргөмжлөл, 1,000,000 төгрөг

7.1.3 Шилдэг байгууллага, аж ахуйн нэгж /гэр хороо/:

- I дүгээр байр - 1. Өргөмжлөл, 5.000.000 төгрөг
- II дугаар байр - 1. Өргөмжлөл, 3.000.000 төгрөг
- III дугаар байр - 1. Өргөмжлөл, 2.000.000 төгрөг
- Тусгай байр - 5. Өргөмжлөл, 1,000,000 төгрөг

7.1.4 Шилдэг тохижилттой хороо /орон сууцны хороо/:

- I дүгээр байр - 1. Өргөмжлөл, 5.000.000 төгрөг + аялах эрх 2
- II дугаар байр - 1. Өргөмжлөл, 3.000.000 төгрөг + аялах эрх 1
- III дугаар байр - 1. Өргөмжлөл, 2.000.000 төгрөг + аялах эрх 1
- Тусгай байр - 3. Өргөмжлөл

7.1.5 Шилдэг тохижилттой хороо /гэр хороо/:

- I дүгээр байр - 1. Өргөмжлөл, 5.000.000 төгрөг + аялах эрх 2
- II дугаар байр - 1. Өргөмжлөл, 3.000.000 төгрөг + аялах эрх 1
- III дугаар байр - 1. Өргөмжлөл, 2.000.000 төгрөг + аялах эрх 1
- Тусгай байр - 3. Өргөмжлөл

7.1.6 Шилдэг тохижилттой гэр хорооллын өрх:


- I дүгээр байр - 1. Өргөмжлөл, 3.000.000 төгрөг
- II дугаар байр - 1. Өргөмжлөл, 2.000.000 төгрөг
- III дугаар байр - 1. Өргөмжлөл, 1.000.000 төгрөг
- Тусгай байр - 100. Өрх бүрт жимсний мод-10

7.1.7 Шилдэг хог хаягдлын үйлчилгээний байгууллага:

- I дүгээр байр - 1. Өргөмжлөл, 5,000,000 төгрөг + аялах эрх 3
- II дугаар байр - 1. Өргөмжлөл, 3,000,000 төгрөг + аялах эрх 2
- III дугаар байр - 1. Өргөмжлөл, 2,000,000 төгрөг + аялах эрх 1

7.2 Шагналыг Нийслэлийн 380 жилийн ойн баярын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хөтөлбөрийн хүрээнд гардуулна.

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 4 дугаар сарын 10-ны өдрийн
А/122 дугаар тушаалын 3 дугаар хавсралт



**"МАНАЙ ХОРОО-МИНИЙ ГУДАМЖ" АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
ТӨСВИЙН ЗАДАРГАА**

/төгрөг/

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж зардал	Нийт зардал
1	Шилдэг дүүргийн шагнал	1-р байр	1	8,000,000	8,000,000
2		2-р байр	1	6,000,000	6,000,000
3		3-р байр	1	4,000,000	4,000,000
4	Шилдэг байгууллага, аж ахуйн нэгжийн шагнал /орон сууцны хороо/	1-р байр	1	5,000,000	5,000,000
5		2-р байр	1	3,000,000	3,000,000
6		3-р байр	1	2,000,000	2,000,000
7		Тусгай байр	5	1,000,000	5,000,000
8	Шилдэг байгууллага, аж ахуйн нэгжийн шагнал /гэр хороо/	1-р байр	1	5,000,000	5,000,000
9		2-р байр	1	3,000,000	3,000,000
10		3-р байр	1	2,000,000	2,000,000
11		Тусгай байр	5	1,000,000	5,000,000
12	Шилдэг орон сууцны хороо	1-р байр	1	5,000,000	5,000,000
13		2-р байр	1	3,000,000	3,000,000
14		3-р байр	1	2,000,000	2,000,000
15	Шилдэг гэр хороо	1-р байр	1	5,000,000	5,000,000
16		2-р байр	1	3,000,000	3,000,000
17		3-р байр	1	2,000,000	2,000,000
18	Шилдэг гэр хорооллын өрх	1-р байр	1	3,000,000	3,000,000
19		2-р байр	1	2,000,000	2,000,000
20		3-р байр	1	1,000,000	1,000,000
21	Шилдэг хог хаягдлын үйлчилгээний байгууллага	1-р байр	1	5,000,000	5,000,000
22		2-р байр	1	3,000,000	3,000,000
23		3-р байр	1	2,000,000	2,000,000
24	Гадаад улсад аялах эрхийн бичиг	хүн	25	2,700,000	67,500,000
25	Өргөмжлөл хэвлүүлэх	ширхэг	21	85,000	1,785,000
26	Эрхийн бичиг хэвлүүлэх	ширхэг	25	2,480	62,000
27	Өргөмжлөл	ширхэг	80	75,000	6,000,000
28	Удирдамжийн танилцуулга ном хэвлүүлэх	ширхэг	800	2,940	2,352,000
29	2018 оны тохижилт, "Манай хороо-Миний гудамж" аяны нэвтрүүлэг	нэвтрүүлэг	1	16,461,000	16,461,000
30	Хашаандаа мод тарьсан иргэдийг урамшуулах	өрх	100	500,000	50,000,000
31	Бусад зардал	-	-	-	6,840,000
Нийт					235,000,000